



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/576

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.1 "а", 29.1.5 "а", 29.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.7 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн IX хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний 1.1.9.5, аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 1.1.9.5 дахь заалтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 15-34 насны зорилтот бүлгийн залуучуудад эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, эмчилгээ хийх ажлын удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах зардал 4 396 500 / Дөрвөн сая гурван зуун ерэн зургаан мянга таван зуун / төгрөгийг "Зорилтот бүлгийн хүн амд ДОХ/ХДХВ/БЗДХ-ыг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх ажлыг эрчимжүүлэх зардал"-аас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /н.Бумансор/-т, батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан, үр дүнг тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газар/н.Мөнхцэцэг/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc

0201803036

Аймгийн Засаг даргын 2018 оны 09  
дугаар сарын 21-ний өдрийн 578 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

## БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАРЫН ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

**Нэг. Үндэслэл** Улсын хэмжээнд Улсад 2017 онд 44300 хурц халдварын тохиолдол бүртгэгдсэнээс зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдварын тохиолдол 15 364 бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 34.7 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар өссөн байна. Нийт өвчлөлийн 28.8 хувийг заг хүйтэн, 43.4 хувийг тэмбүү, 27.6 хувийг трихомониаз, 0.2 хувийг ХДХВ/ДОХ-ын халдвар тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тэмбүүгийн өвчлөл 477 тохиолдлоор нэмэгдсэн. Сүүлийн 5 жилийн дунджаар төрөлхийн тэмбүүтэй бүртгэгдсэн тохиолдлын 57.1 хувь нь 15-24 насны жирэмсэн эмэгтэйчүүдээс төрсөн байна. ХДХВ-ийн халдвартай гэж албан ёсоор бүртгэгдсэн 249 хүн байгаагаас 2017 онд 25 шинэ тохиолдол бүртгэгдсэн. Эдгээр халдвартай хүмүүсийн 16.9 орчим хувь нь 15-24 насныхан, үүнээс 80 орчим хувь нь эрэгтэйчүүд байна.

Аймгийн хэмжээнд 14 төрлийн цочмог халдварт өвчний тохиолдол 673 бүртгэгдэж, бэлгийн замаар дамжих халдварын тохиолдол 45%-ийг эзэлж байна. Сүүлийн 5 жилийн дунджаар нийт хурц халдварт өвчний дотор бэлгийн замаар дамжих халдвар 40 гаруй хувийг эзэлж байна. Үүнээс 50 хувь нь тэмбүүгийн халдварын тохиолдол байна.

Орхон аймагт нийт хүн амын 15% /14911/-ийг 15-24 насны залуучууд эзэлж байна. Нийт бүртгэгдсэн бэлгийн замаар дамжих халдварын тохиолдлын 50 хувь нь эдгээр насны залуучууд байна. Иймд БЗДХ-ын урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг зохион байгуулж өвчлөлийг илрүүлж эмчлэн эрүүлжүүлэх БЗДХ/НҮЭМ-ийн эрүүл мэндийн боловсрол олгох, зайлшгүй шаардлагатай байна.

**Хоёр. Зорилго:** Зорилтот бүлгийн хүн амын дунд бэлгийн замаар дамжих халдварын эрт илрүүлэг үзлэг зохион байгуулах

**Гурав. Хамтран ажиллах байгууллага:** Аймгийн Засаг даргын тамгын газар, Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв Боловсрол соёл урлагийн газар, ХГБЗХГ, их дээд сургуулийн захиргаа

### **Дөрөв. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

#### **1. Удирдлага арга зүйгээр хангах баг**

Багийн ахлагч: Г. Энхжаргал- Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга  
Нарийн бичиг: Б. Цэндбаяр – Бэлгийн замаар дамжих халдвар, сүрьеэгийн тандалт сэргийлэлт, өсвөр үе, залуучуудын эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн  
Гишүүд: Б.Жаргалсайхан- Өрхийн Анагаах ухааны мэргэжилтний холбооны тэргүүн  
О.Анхбаяр- Эрүүл мэндийн газрын Эмийн бодлого чанар аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн  
Д. Отгондэлгэр- Эрүүл мэндийн газрын эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

#### **2. Оношилгоо, эмчилгээ хийх баг**

Багийн ахлагч: Д.Цэвэлмаа- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн БЗДХ/ДОХ-ын кабинетын эмч  
Гишүүд: Л.Баяржаргал- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн клиник лабораторийн эрхлэгч

С.Тунгалаг- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн БЗДХ/ХДХВ/ДОХ-ын кабинетын сувилагч

Т.Удвал- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн лаборант

П.Цэцэгдэлгэр- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн лаборант

Хяналт үнэлгээний баг: Н.Мөнхбаяр- Эрүүл мэндийн газрын хяналт шинжилгээ , үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн

О.Батцэнгэл- Эрүүл мэндийн газрын тусламж үйлчилгээ чанар аюулгүй хариуцсан мэргэжилтэн

Б.Будсүрэн- Эрүүл мэндийн газрын дархлаажуулалт, зоонозын өвчний тандалт сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн

#### Тав. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажил үүргийн хуваарь

##### 1. Удирдлага арга зүйгээр хангах баг

- Үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах төсвийг хуваарилах
- Хамтран ажиллах байгууллага, аж, ахуйн нэгжүүдийн уялдаа холбоог хангах
- Мэдээ, тайлан хүлээн авч нэгтгэх,  $\lambda \delta \alpha \zeta \text{ í } \alpha \delta \alpha \text{ í } \epsilon \epsilon \delta \delta \delta \epsilon \delta \delta$
- Үйл ажиллагааг дэмжих, өвчлөлийн мэдээ, тайлан, судалгааны дүнг холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь илгээх, орон нутгийн удирдлагуудад мэдээллийг хүргэж, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Санхүүгийн тайлан, эм, оношлуурын зарцуулалтанд хяналт тавих
- Үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийж, арга зүйгээр хангах, дэмжлэг үзүүлэх

##### 2. Оношилгоо, эмчилгээ хийх баг

- Зорилтот бүлгийн хүн амын дунд үзлэг шинжилгээг зохион байгуулах
- Үзлэг шинжилгээнд шаардагдах оношлуур, эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах
- Лабораторийн шинжилгээг хурдавчилсан тестээр тухайн газарт хийх, шаардлагатай тохиолдолд сорьц цуглуулан, лабораторит шинжилгээ хийх
- Мэдээллийн нууцлалыг хадгалах
- Илэрсэн өвчлөлийг хяналтанд авах, эмчлэх арга хэмжээг зохион байгуулах
- Үзлэгийн тайлан мэдээг ЭМС-ын 450 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу цаг хугацаанд нь мэдээлэх
- Эм, оношлуурын зарцуулалтын тайланг үнэн зөв гаргаж, тайлан бүрдүүлэлт хийх

#### Зургаа. Хамрагдах зорилтот бүлэг:

- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид
- Их дээд сургуулиудын оюутан залуучууд

#### Долоо. Зохион байгуулах үйл ажиллагаа:

- Зорилтот бүлгийн хүн амын дундах БЗДХ/ХДХВ/ДОХ-ыг эрт илрүүлэх үзлэг шинжилгээг хийж, өвчтэй илрэгсдийг хяналтанд авч эмчлэх

#### Найм. Оношлуурын хуваарь

№	Үзлэгт хамрагдах бүлэг	Тэмбүү/Syphilis/	ХДХВ/HIV/
1	Ахлах ангийн сурагчид	500	-
Оюутан, залуучууд			
1	ТИС	300	100
2	МУИС	250	100
3	ОМСҮТ	300	200
4	ХАА-н МСҮТ	100	50
5	Маргад дээд сургууль	50	50
<b>Нийт</b>		<b>1500</b>	<b>500</b>

#### Ес. Үйл ажиллагаа зохион байгуулах хуваарь

№	Үзлэгт хамрагдах бүлэг	Үзлэг хийх байгууллага	Хугацаа	Үзлэгт хамрагдах хүний тоо
1	Ахлах ангийн сурагчид	БОЭТ	IX/25-X/28	500
2	ТИС		IX/19	300
3	Орхон МСҮТөв		IX/23-24	250
4	Маргад дээд сургууль		X/03	300

5	ХАА-н МСҮТ		X/09	100
6	МУИС		X/16	50
<b>Нийт</b>				<b>1500</b>

-ОоО-

Аймгийн Засаг даргын 2018 оны 09 сарын 19-ний өдрийн 38 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

**БЗДХ, ХДХВ-ИЙН ХАЛДВАР ИЛРҮҮЛЭХ ОНОШИЛГОО,  
ЭМЧИЛГЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨСӨВ**

**1.Оношилгоо зохион байгуулах зардал**

№	Шинжилгээний материалын төрөл	Санхүүжилт		
		Захиалгын тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт
1	ХДХВ илрүүлэх хурдавчилсан оношлуур	500	1430	715000
2	Тэмбүүгийн хурдавчилсан оношлуур	1500	1265	1897500
3	Вакум теннер, зүү	1500	330	495000
4	Хөвөн-спирт	1*100x15 хайрцаг	50	75000
5	Аюулгүй хайрцаг	10	1400	14000
6	Үзлэг зохион байгуулах илүү цагийн урамшуулал	5 хүн	1 000 000	1 000 000
7	Шатахууны зардал		1830	200 000
Бүгд				4 396 500

**2.Үзлэг зохион байгуулах илүү цагийн тооцоо**

№	Үзлэг зохион байгуулах мэргэжилтэн	Ажиллах хугацаа	Өдөрт ажиллах цагийн хөлс/төг/	Нийт урамшуулал
1	Д.Цэвэлмаа- БОЭТ-ийн БЗДХ-ын кабинетийн эмч	10 өдөр	20 000	200 000
2	Л.Баяржаргал- БОЭТ-ийн лабораторийн эрхлэгч	10 өдөр	20 000	200 000
3	С.Тунгалаг- БОЭТ-ийн БЗДХ-ын кабинетийн сувилагч	10 өдөр	20 000	200 000
4	Т.Удвал- БОЭТ-ийн серологи лаборант	10 өдөр	20 000	200 000
5	П.Цэцэгдэлгэр- БОЭТ-ийн серологи лаборант	10 өдөр	20 000	200 000